



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 сарын 20 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь олон нийтийн сүлжээнд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хүний эрхийг хангах асуудлаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах хууль тогтоомж

2.1.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Хүүхэд хамгааллын тухай хууль², Кибер аюулгүй байдлын тухай хууль³, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль⁴, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль⁵, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль олон нийтийн сүлжээнд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс хамгаалах, хүний эрхийг хангах асуудлаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, олон нийтийг соён гэгээрүүлэхтэй холбоотой харилцаанд үйлчилнэ.

3.2.Олон нийтийн сүлжээнд гурваас доош тооны хэрэглэгч хоорондоо харилцахад энэ хууль үйлчлэхгүй.

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Хүүхэд хамгааллын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

³ Кибер аюулгүй байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1998 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” гэж Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 20.1.2-т заасныг;

4.1.2.“контентыг нийтлэх” гэж хэрэглэгч контентыг олон нийтийн сүлжээнд нийтэд нээлттэй хүргэхийг;

4.1.3.“контентыг түгээх” гэж нийтэлсэн контентыг олон нийтийн сүлжээнд бусад этгээдэд дамжуулахыг;

4.1.4.“контентыг түдгэлзүүлэх” гэж олон нийтийн сүлжээнд нийтэлсэн контенттой танилцах, түгээх боломжийг тодорхой хугацаанд хязгаарлахыг;

4.1.5.“ногоон суваг” гэж зөрчилтэй контентыг шийдвэрлэх, харилцан мэдээлэл солилцох чиглэлээр олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ажиллах сувгийг;

4.1.6.“олон нийтийн сүлжээ” гэж интернэт сүлжээ ашиглан контентыг нийтэд нийтлэх, түгээх, харилцан мэдээлэл солилцох зориулалт бүхий программ хангамжийг;

4.1.7.“олон нийттэй харилцах нэгж” гэж кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн бүтцийн нэгжийг;

4.1.8.“төлөөлөгчийн газар” гэж Иргэний хуулийн⁶ 29.3-т заасныг;

4.1.9.“үйлчилгээ эрхлэгч” гэж олон нийтийн сүлжээний үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийг;

4.1.10.“хэрэглэгч” гэж олон нийтийн сүлжээнд бүртгэгдсэн, хэрэглэгчийн хаягтай хүн, хуулийн этгээдийг;

4.1.11.“хэрэглэгчийн хаяг” гэж олон нийтийн сүлжээнд хэрэглэгчийг ялган таних зориулалт бүхий үг, үсэг, тоо болон бусад тэмдэгтээс бүрдсэн мэдээллийг;

4.1.12.“хүний хувийн мэдээлэл” гэж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.11-д заасныг.

4.2.Энэ хуулийн 4.1.5-д заасан ногоон сувгийг хэрэгжүүлэх эрхийг олон улсад зөвшөөрөгдсөн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад олгож болно.

5 дугаар зүйл.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалахад баримтлах зарчим

5.1.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалахад дараах зарчмыг баримтална:

⁶ Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

5.1.1.хууль дээдлэх;
5.1.2.үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг хүндэтгэх;
5.1.3.хүнийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх;
5.1.4.хүний нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

5.1.5.хүний хувийн мэдээллийг хамгаалах;
5.1.6.үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг хамгаалахад чиглэх;

5.1.7.олон нийтийн сүлжээний зохистой хэрэглээг төлөвшүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗӨРЧИЛТЭЙ КОНТЕНТ

6 дугаар зүйл.Зөрчилтэй контент

6.1.Зөрчилтэй контентод олон нийтэд хүргэхээр нийтэлсэн текст, тэмдэг, зураг, дуу, хөдөлгөөнт дүрс болон бусад хэлбэр бүхий дараах мэдээллийг хамааруулна:

6.1.1.Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийг гутаан доромжилсон;
6.1.2.цахим сүлжээ ашиглан залилсан, залилахыг завдсан;
6.1.3.хүүхдийн бие махбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан;

6.1.4.хүчирхийлэл, садар самууныг уриалсан, сурталчилсан;
6.1.5.хүнийг заналхийлэх, амиа хорлох, бие махбодод нь гэмтэл учруулахыг уриалсан, сурталчилсан;

6.1.6.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг уриалсан, сурталчилсан;

6.1.7.экстремист үйл ажиллагаа явуулах, үндэсний эв нэгдлийг бусниулах, төрийн болон албаны нууцыг задруулах, террорист үйлдэл хийх, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн шинжийг агуулсан, гэмт хэрэг үйлдэхэд өдөөн турхирсан, уриалсан;

6.1.8.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхсан;

6.1.9.оюуны өмчийн эрхийн зөрчилтэй;
6.1.10.гэмт хэрэг, зөрчилд тооцогдох үйлдлийг нарийвчлан зааварчилсан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдэхийг өдөөн турхирсан, хатгасан, уриалсан, сурталчилсан, дэмжсэн;

6.1.11.хүүхдийг гуйлга гуйхад, тэнэмэл, хараа хяналтгүй амьдрахад татан оруулсан, өдөөн хатгасан, уриалсан, сурталчилсан;

6.1.12.мэдээлэл нийтлэгдсэн олон нийтийн сүлжээний нөхцөл, шаардлагыг зөрчсөн.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан контентын зөрчилтэй эсэхийг хянан шийдвэрлэхэд дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

6.2.1.контент нь хүн, хуулийн этгээд, эсхүл нийгмийн тодорхой бүлгийн эсрэг чиглэсэн байдал;

6.2.2.контентын агуулга, түүнийг илэрхийлсэн хэлбэр, хэв маяг, ашигласан үг хэллэг;

6.2.3.контентыг нийтэлсэн, түгээсэн арга хэлбэр, давтамж;

6.2.4.контентын улмаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд болон нийгэм, эдийн засагт учруулж болох эрсдэл.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7 дугаар зүйл. Үйлчилгээ эрхлэгч, түүний эрх, үүрэг

7.1.Үйлчилгээ эрхлэгч дараах эрх, үүрэгтэй байна:

7.1.1.зөрчилтэй контенттой холбогдуулан хэрэглэгчээс гомдол, мэдээлэл авах;

7.1.2.зөрчилтэй контент, эсхүл зөрчилтэй контент агуулсан хэрэглэгчийн мэдээллийг гаргуулах, хаягийг түдгэлзүүлэх, устгах, мэдээллийн тархцыг бууруулах, хэрэглэгчийн хаягийг баталгаажуулах талаар олон нийттэй харилцах нэгжийн хүсэлт, шийдвэрийг хүлээн авч, хянан шийдвэрлэх;

7.1.3.энэ хуулийн 7.1.2-т заасан хүсэлтийн тоо, түүнийг хянан шийдвэрлэсэн тайлан, мэдээг жил бүр олон нийттэй харилцах нэгжид хүргүүлэх;

7.1.4.Монгол Улсаас бүртгэлтэй 300 000 буюу түүнээс дээш тооны хэрэглэгчтэй бол төлөөлөгчийн газар байгуулах;

7.1.5.хэрэглэгчийг харилцах утасны дугаар, эсхүл цахим шуудангийн хаягаар баталгаажуулан бүртгэх;

7.1.6.хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалах;

7.1.7.зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг 7 хоногийн дотор хянан шийдвэрлэх.

8 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг

8.1.Хэрэглэгч дараах эрх, үүрэгтэй байна:

8.1.1.зөрчилтэй контентын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд олон нийттэй харилцах нэгж, үйлчилгээ эрхлэгчид хандаж шийдвэрлүүлэх;

8.1.2.зөрчилтэй контентыг олон нийтийн сүлжээнд нийтлэхгүй, түгээхгүй байх;

8.1.3.хэрэглэгчийн хаяг, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

8.1.4.зөрчилтэй контентыг олон нийтийн сүлжээнд нийтэлсэн, түгээсэн нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол, хор уршиг учруулсан бол гэм хорыг арилгах;

8.1.5.нийтэлсэн контентын үнэн зөв байдлыг хариуцах;

8.1.6.олон нийттэй харилцах нэгжийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗӨРЧИЛТЭЙ КОНТЕНТЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

9 дүгээр зүйл.Зөрчилтэй контентын талаар хүсэлт гаргах

9.1.Зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүн, хуулийн этгээд, зөвлөмж, шаардлагыг хуульд заасан эрх бүхий байгууллага олон нийттэй харилцах нэгжид цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

9.2.Олон нийттэй харилцах нэгжийн үйл ажиллагааны журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10 дугаар зүйл.Зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэх

10.1.Олон нийттэй харилцах нэгж нь зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч бүртгэн, хянан шийдвэрлэнэ.

10.2.Олон нийттэй харилцах нэгж нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн агуулга, нөхцөлийг харгалзан хүсэлтийг 72 цагийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд гарсан санал, дүгнэлтийг үндэслэн кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв нь дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж, хүсэлт гаргасан этгээдэд даруй мэдэгдэнэ:

10.2.1.хүсэлтийг хүлээн авахаас татгалзах;

10.2.2.хүсэлтийг шийдвэрлэж, шийдвэр, зөвлөмж, шаардлагыг ногоон сувгийг хариуцан ажиллаж байгаа байгууллага болон олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид хүргүүлэх;

10.2.3.харьяаллын дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлж, хамтран ажиллах.

10.3.Энэ хуулийн 10.2-т заасан хүсэлт хянан шийдвэрлэх хугацааг шаардлагатай тохиолдолд нэг удаа ажлын гурван өдрөөр сунгаж болно.

10.4.Олон нийттэй харилцах нэгж нь зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хянан шийдвэрлэхдээ лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах, шинжээч ажиллуулах, Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг авч болно.

ТАВДУГААР БҮЛЭГ
ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

11 дүгээр зүйл.Олон нийтийн сүлжээний зохистой хэрэглээг
төлөвшүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх соён
гэгээрүүлэх үйл ажиллагаа

11.1.Олон нийттэй харилцах нэгж нь олон нийтийн сүлжээнд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс хамгаалах, үүсэх эрсдэлийг бууруулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.1.1.олон нийтийн сүлжээний зохисгүй хэрэглээ, зан үйл, хор аюул учруулж болзошгүй шалтгаан, нөхцөлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх арга барилд сургах чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

11.1.2.олон нийтийн сүлжээний зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэх;

11.1.3.олон нийтийн сүлжээнд өөрийгөө болон бусдыг хамгаалах зан суртахуун, хандлага, чадварыг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;

11.1.4.олон нийтийн сүлжээний зохисгүй хэрэглээнээс гэмт хэрэг, зөрчилд өртөх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдэгдэл, зөвлөмжийг хүн, хуулийн этгээдэд өгөх;

11.1.5.олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах талаар гадаад улсын болон олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ

12 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

12.1.Энэ хуулийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР